

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ**

2021 оны 12 дугаар сарын 13

Багануур дүүрэг

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний хувь	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7	8
			Салбар чиглэл: 1				
1.е. Засгийн газрын тогтоол							
1.	1.	2018.02.06 Дугаар 43 Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 1.10. Улаанбаатар хотын дагуул хот, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга	Паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр дараах бодлогын баримт бичгүүдэд тусгуулсан. Үүнд: ➢ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6.1.11.3 “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна. ➢ Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 4.3.3.7 “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалт ➢ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний	100%	100%		

		<p>Б.Баярсайхан нарт, дагуул хот, дэд төв, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;</p>	<p>3.2.2.2 “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”ийн дэд бүтцийг байгуулна.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Багануур дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.1 “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”ийн дэд бүтцийг байгуулна. ➤ 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, гадна инженерийн шугам, сүлжээний иж бүрэн зураг төслийг хүлээж авсан. ➤ 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн чуулганаар нийслэлийн 2022 оны төсөвт паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам барихад шаардлагатай 4,3 тэрбум төгрөгөөс 1,087 сая төгрөгийг тусгаж батлуулсан. 				
2.	2.	<p>2018.08.22</p> <p>Дугаар 258</p> <p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</p> <p>1.2. Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Тайлант оны байдлаар албан хаагчдаас байгууллагад гаргасан нийт 4 өргөдлийг хүлээн авсан ба хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй. ➤ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, дүүргийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст тус тус хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. ➤ Байгууллагын удирдлага тайлант онд нийт 13 иргэдтэй уулзалт хийж дараах чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> 1. Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагаа 	100%	100%		

		сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх;	<p>2. Паркийн өнөөгийн байдал</p> <p>3. Паркийн эрх зүйн байдлын хэм хэмжээ</p> <p>4. Паркад хэрэгжих боломжтой төсөл, хөтөлбөр</p> <p>5. Паркийн хүрээнд байгуулагдах барилгын материалын үйлдвэрлэлийн хөрөнгө оруулагчдын талаарх сүүлийн үеийн мэдээлэл</p> <p>6. Паркийн газар нутагт баригдах цахилгаан шугам сүлжээний асуудал</p> <p>Удирдлагын иргэдтэй хийсэн уулзалтыг улирал тутам хугацаанд нь НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд тайлагнан ажиллаж байна.</p>				
3.	1.4. Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох	Тайлант онд сул орон тоо гараагүй болно.	100%	100%			
4.	1.7. Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх,	Байгууллагын дотоод журамд тусгасан бөгөөд зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	100%	100%			

		хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;					
	5.	1.9. Төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	<ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын цаг бүртгэлийг 2019 оны 2 дугаар сараас эхлэн хурууны хээний машинаар бүртгэж, түүнд хяналт тавин ажиллаж байна. ➤ Тайлант оны хугацаанд цар тахалтай холбогдон гарсан тогтоол, захирамж, шийдвэрийн дагуу шаардлагатай тохиолдолд албан хаагчдыг гэрээс нь цахимаар ажиллуулан, ажлын цаг ашиглалт, албан үүргийн хэрэгжилтэд байгууллагын Дотоод хяналт шалгалтын комисс шууд хяналт тавин ажилласан. 	100%	100%		
3.	6.	<p>2020.12.16</p> <p>Дугаар 216</p> <p>Журам шинэчлэн батлах тухай</p> <p>Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах хэрэгжилтийг хангах журмын</p> <p>3.2. Салбарын болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын стратеги төлөвлөгөөг улсын болон аймаг, орон нутгийн төсөв, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, улс, аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын 2021-2024 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 				

		хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.					
4.	7.	2020.12.16 Дугаар 217 Журам шинэчлэн батлах тухай Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.1. Төсвийн шууд захирагч нь тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө (цаашид “төлөвлөгөө” гэх) боловсруулан баталж, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 				
5.	8.	2020.12.16 Дугаар 218 Журам шинэчлэн батлах тухай Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын	<ul style="list-style-type: none"> ➤ Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Газрын даргаар батлуулсан. ➤ Тайлант онд тус тогтоолоор батлагдсан журманд заасан хугацаанд Захиргааны болон Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтнүүд албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг хянаж, баталгаажуулан 	100%	100%		

		гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам	байгууллагын дотоод хяналт шалгалтын комисст өгч, тус комисс холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод журмыг баримтлан уг тогтоолын 4.14-т дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар удирдлагад танилцуулан, үнэлгээний хуудсыг баталгаажуулж хэрэгжилтийг ханган ажилласан.				
4.	9.	2021.02.17 Дугаар 43 Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 1.1. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;	➤ 2021 оны төсөвт цалин хөлс, байр ашиглалтай холбоотойгоос бусад урсгал болон бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, томилот, сургалтын зардал тусгагдаагүй. Хэмнэлтийн горимд ажилласан.	100%	100%		
	10.	1.2. Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо	➤ НЗД-ын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/757 дугаар захирамжаар баталсан бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарт багтаан 2021 оны 1 дүгээр сард Газрын даргын А/01 дүгээр тушаалаар байгууллагын ажлын чиг үүрэг, албан тушаал, орон тоог шинэчлэн баталсан.	100%	100%		

		хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;	<ul style="list-style-type: none"> ➤ Тайлант онд шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй бөгөөд батлагдсан орон тооны хязгаарт байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа. 				
11.	1.3. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;	<ul style="list-style-type: none"> ➤ Дотоод бүтэц зохион байгуулалтыг байгууллагын 2021-2024 оны стратеги болон 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбогдуулж албан тушаалын чиг үүргийг оновчтой тодорхойлж чиг үүргийн давхардалгүй ажиллаж байна. ➤ Мөн шагнал, урамшуулал олгохгүй, зочин төлөөлөгч хүлээн авахгүй, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүйгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 	100%	100%			
12.	1.4. Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах,	<ul style="list-style-type: none"> ➤ Манай байгууллагад төрийн болон өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төсөв зардал энэ онд батлагдаагүй. 	100%	100%			

		фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;					
13.	1.5. Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;	<ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын удирдлага нийслэл болон дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралд цахимаар оролцож байна. ➤ Байгууллагын хурлыг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд фейсбүк чат болон zoom ашиглан цахимаар зохион байгуулж байна. ➤ 2021 оны байдлаар нийслэлээс зохион байгуулсан 16, дүүргээс зохион байгуулсан 6 нийт 22 цахим сургалтад холбогдох инженер, мэргэжилтнүүд хамрагдсан. 	100%	100%			
14.	1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;	<ul style="list-style-type: none"> ➤ Ямар нэгэн ой, урлагийн наадам, спорт арга хэмжээнд оролцохгүй, аялал зугаалга зохион байгуулахгүйгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 	100%	100%			
15.	1.7. Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;	<ul style="list-style-type: none"> ➤ Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, коронавирусын нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж байна. 	100%	100%			
16.	1.8. Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны	<ul style="list-style-type: none"> ➤ Манай байгууллага түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд түрээсийн 	100%	100%			

		хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах;	төлбөрт ашиглалтын (дулаан, ус, цахилгаан зэрэг) зардлууд бүгд багтаж, жилийн 4 улиралд тогтмол дүнгээр төлөгдөх гэрээтэй ажилладаг.				
	17.	1.9. Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах	<ul style="list-style-type: none"> ➢ Байгууллагын дотоод сүлжээ болон ERP системийг ашиглан баримт бичгийг солилцож байна. ➢ Байгууллага хоорондын албан бичгийг E-токэн төхөөрөмж ашиглан солилцож, шийдвэрлэж байна. ➢ Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн. Үүнтэй холбоотой бичиг хэрэг, цаас, хэвлэгчийн хорны зардлыг бууруулж ажиллаж байгаа. 	100%	100%		
5.	18.	<p>2020.03.18</p> <p>№96</p> <p>Үндэсний хөтөлбөр батлах тухай (Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III)</p> <p>3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн дэмжлэгээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн</p>	<ul style="list-style-type: none"> ➢ НЗДТГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 03/1665 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. 	100%	100%		

		холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.					
1.ё. Ерөнхий сайдын захирамж							
6.	19.	2020.07.01 №99 Төлөвлөгөө батлах тухай (Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2020-2022) 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	➤ Тус захирамжаар батлагдсан "Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн тайланг НЗДТГ-ын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 08/2471 дугаартай албан бичгээр өгсөн хавсралт маягтын дагуу гаргаж Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 101 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Соён гэгээрүүлэх тасагт хүргүүлэв.	100%	100%		
			Хэсгийн дундаж	100%	100%		
			Салбар чиглэл: 2				
2.е. Засгийн газрын тогтоол							
7.	20.	2020.01.26 Дугаар 30 Шинэ коронавирүсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх	➤ Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, амны хаалт, нэг удаагийн бээлий, Паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн гар халдваргүйжүүлэгч, ам, хоолой зайлах уусмалаар ханган, өдөр бүр ажлын байранд чийгтэй цэвэрлэгээг хийж, 2 цаг	100%	100%		

		<p>чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p>11. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа ухуулга, сурталчилгаа хийх, ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга, захирал нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт уриалсугай.</p>	<p>тутамд хаалганы бариулыг спиртээр ариутгаж, агаар сэлгэлтийг хийн, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин ажиллаж байна.</p> <p>➤ Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар ЭМЯ-наас өгч байгаа зөвлөмж, цаг үеийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулж байна.</p>				
8.	21.	<p>2021.01.04</p> <p>Дугаар 02</p> <p>Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай</p> <p>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 17 дугаар жарны цагаагчин үхэр жилийн Цагаан сарын баярыг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэж үзсүгэй.</p>	<p>➤ Тогтоолын хэрэгжилтийг ханган албан хаагчид 17 дугаар жарны цагаагчин үхэр жилийн Цагаан сарын баярыг тэмдэглээгүй.</p>	100%	100%		
9.	22.	<p>2021.02.10</p> <p>Дугаар 27</p>	<p>➤ Тогтоосон хугацаанд нийт ажилчдын 90%-ийг цахимаар ажиллуулах зохион байгуулалтыг хийсэн.</p>	100%	100%		

		<p>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай</p> <p>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цагаас мөн оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсүгэй.</p>	<p>➤ Албан хаагчид хүнсний бүтээгдэхүүнээ нөөцлөн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд гэрээсээ гаралгүй хөл хорионы дэглэмийг чанд баримталсан.</p>				
10.	23.	<p>2021.04.08</p> <p>Дугаар 91</p> <p>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай</p> <p>1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг</p>	<p>➤ Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/265 дугаар захирамжийн 2.2, 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн “<i>Нутгийн захиргааны нийт байгууллагууд ажилтан, албан хаагчдын 10 хүртэл хувийг ажиллах хуваарь, нэрсийн жагсаалтыг</i></p>	100%	100%		

		дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.	батлах” үүрэг даалгаврын дагуу 2021 оны 04 дүгээр сарын 10-25-ны өдрүүдэд ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 49 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хүний нөөцийн удирдлагын тасагт хүргүүлж тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан.				
11.	24.	2021.04.23 Дугаар 104 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.	<ul style="list-style-type: none"> ➢ Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/313 дугаар захирамжийн дагуу албан хаагчдад өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулахгүй байхад анхаарч, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд гэрээс гарахгүй байх, хамгийн ойр үйлчилгээний байгууллагаар хөдөлгөөн багатай үед үйлчлүүлэн, халдвар хамгааллын дэглэмийг сахихыг зөвлөж, хэрэгжилтийг бүрэн хангасан. ➢ 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврын 3 дахь заалтын дагуу <i>(Төрийн захиргааны болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ажилтан, албан хаагчдыг ажлын байранд нь ажиллуулахгүй байх, хуулийн этгээдийн үйл ажиллагааг тусгай горимд шилжүүлж, зайлшгүй шаардлагаар биечлэн ажиллах</i> 	100%	100%		

			<p>албан хаагчдын тоог бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах) ажилчдыг ажлын байранд нь ажиллуулахгүйгээр цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ба төлөвлөгөөт албан бичгүүд илгээх зайлшгүй шаардлагаар ажлын байранд ирж ажиллах тохиолдолд ажлын үнэмлэхтэй, QR кодыг уншуулан, богино хугацаанд ажил үүргээ гүйцэтгэх зохин байгуулалтын арга хэмжээг авсан.</p> <p>➤ Байгууллагын үндсэн үйл ажиллагааг жигд тогтвортой хэрэгжүүлэн ямар нэгэн эрсдэл доголдолгүй ажилласан.</p>				
12.	25.	<p>2021.05.05</p> <p>Дугаар 115</p> <p>Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай</p> <p>1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 06:00 цагаас мөн оны 6 дугаар сарын 2-ны өдрийг хүртэлх хугацаанд</p>	<p>➤ Уг тогтоолтой холбогдон гарсан нийслэлийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/357 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж 05 дугаар сард байгууллагын дотоод хяналт шалгалтын комисс бүх албан хаагчдыг дархлаажуулалтын 1-р тунд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>➤ 2-р тунд албан хаагчдын биеийн байдлыг харгалзан үе шаттайгаар хамруулсан.</p> <p>➤ Халдварын нөхцөл байдал бүрэн арилаагүй байгаатай холбогдуулан гэр ажил маршрутаар явах, "Ковид 19 эрсдэл систем"-ийг гар утсандаа татан өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулахгүй, шаардлагатайгаас бусад тохиолдолд гэрээс гарахгүй, халдвар хамгааллын дэглэмийг сахихыг нийт албан хаагчдад үүрэг болгосон.</p>	100%	100%		

		гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.	<ul style="list-style-type: none"> ➢ “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх зөвлөгөөг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. 				
13.	26.	<p>2021.05.05</p> <p>Дугаар 118</p> <p>Журмын хавсралтыг өөрчлөн батлах тухай</p> <p>1. “Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын хавсралтыг энэ тогтоолын хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.</p>	<ul style="list-style-type: none"> ➢ Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: ➢ Уралдаан тэмцээн, аялал зугаалгын үйл ажиллагааг зохион байгуулаагүй. ➢ Ажилтнуудын ажлын байрны хоорондын зайг суудал тутамд 2м байхаар зохион байгуулалт хийсэн. ➢ Баримт бичгийг байгууллагын дотоод сүлжээ болон ERP системийг ашиглан солилцож байна. ➢ Байгууллагын ажилчид хэвийн горимоор буюу 1-5 дугаар саруудад 08:30-17:30, бусад хугацаанд 08:00-17:00 цагаар ажиллаж, хөдөлгөөнд оролцохдоо биедээ ажлын болон иргэний үнэмлэхийг авч явсан. ➢ Тайлант онд ариутгал, халдваргүйтгэлийг “Их хурай” ХХК-аар гүйцэтгүүлж, ажлын байранд чийгтэй цэвэрлэгээг өдөр бүр хийн халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажилласан. ➢ Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэг буюу хаалганы гадна талд байршуулан хэрэгжилтэд шууд хяналт тавин ажиллаж байна. 	100%	100%		
14.	27.	<p>2021.08.25</p> <p>Дугаар 259</p>	<ul style="list-style-type: none"> ➢ Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118, 259 дүгээр тогтоолын дагуу улс, нийслэлийн Онцгой комиссоос гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг, халдвар тархалтын “Улбар шар” 	100%	100%		

		<p>Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай</p> <p>Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.</p>	<p>түвшинд Ковид-19 тархалтыг бууруулах, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хариу арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу нийслэлийн Онцгой комиссоос “Ковид-19 халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх чиглэл өгсөн.</p> <p>➤ Тус төлөвлөгөөний холбогдох заалтын хүрээнд, Тухайлбал 1.5 дахь заалтын дагуу дархлаажуулалтын нэмэлт тунд хамрагдаагүй албан хаагчдын судалгааг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр pokshuurhaishtab@gmail.com хаягаар, 1.4 дэх заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа талаарх биелэлтийг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 178 дугаартай албан бичгээр нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт хүргүүлсэн.</p> <p>➤ Мөн 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн <i>(Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 20 дугаар цахим хурлын тэмдэглэлийн 1.1 дэх заалтын дагуу байгууллагын албан хаагчдад ажлын нэг өдрийн чөлөө олгож, дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч, хамрагдаагүй шалтгааны талаарх судалгааг 2021 оны 12 дугаар</i></p>				
--	--	---	--	--	--	--	--

			<p>сарын 03-ны дотор nok@ulaanbaatar.mn цахим хаягаар ирүүлэх) үүрэг чиглэлийн хүрээнд вакцины 3-р тунд хамруулах ажлыг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын нийт 10 ажилтнаас 6 ажилтан 3-р тунд хамрагдаад байна. ➤ Спутник вакцин тариулсан 2 ажилтанд 3-р тунд ямар вакцин сонгох, үр дүнг яаж харгалзах тухайд Эрүүл мэндийн төвөөс тодорхой зөвлөмж ирүүлэхгүй байгаа тул тухайн иргэд хүлээнэж байна. ➤ 2 албан хаагч 1-р тунгийн дараа вакцинаас харшилсан. Харшлийн хорыг эмчлүүлэх явцад 2-р тунд хамрагдаж амжаагүй байхдаа ковид-19 халдвараар өвчилж одоогоор нөхөн сэргээх эмчилгээ хийлгэж байна. ➤ Дээрх 4 албан хаагчийн вакцины 3-р тунд хамрагдаагүй шалтгааны талаарх мэдээллийг нэгтгэн 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр nok@ulaanbaatar.mn хаягаар хүргүүлсэн. 				
15.	28.	<p>2021.10.13</p> <p>Дугаар 314</p> <p>Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай</p> <p>Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор энэ</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Засгийн газрын хүчингүй болсон тогтоолын жагсаалтыг албан хаагчдад танилцуулж ажилласан. 	100%	100%		

		тогтоолын хавсралтад заасан Засгийн газрын тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.					
2.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
16.	29.	2021.12.08 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавих, сайжруулсан түлшний нөөц, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр өгсөн үүргийн хүрээнд нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 15 дугаар тушаалаар батлагдсан нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг дээрх чиглэл болон дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэх талаар хороодод ажиллуулах хуваарийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүн мэдээг удирдамжид заасны дагуу ирүүлэх	<ul style="list-style-type: none"> ➤ 2020 онд НОК-ын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 13 дугаар /өргөтгөсөн/ хурлын тэмдэглэлийн 7.2 дахь заалтын дагуу ЗГ-ын 2018 оны 62, 2020 оны 189 дүгээр тогтоолыг албан хаагчдад танилцуулан мэдээлэл хүргэсэн. ➤ 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн НУАШЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын 3 дахь заалтын дагуу сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар, зөвлөгөө, сэрэмжлүүлгийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд хүргэсэн. ➤ НОК-ын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 15 дугаар тушаалыг албан хаагчдад танилцуулсан. ➤ Уг тушаалын нэгдүгээр хавсралтад Нийслэлийн төвийн 6 дүүрэгт сайжруулсан түлшний нөөц, борлуулалт, түгээлт, дархлаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахаар хуваарь гарсан байгаа ба хяналт тавих болон хариуцаж ажиллах байгууллагад манай байгууллага хуваарилагдаагүй тул хоёрдугаар хавсралтаар батлагдсан удирдамжийн 1.2 дахь заалтын дагуу Угаарын хийн мэдрэгчийг зөв ашиглах, угаарын хийн хордлогоос сэргийлэх зөвлөмж мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав. 	100%	100%		

		Хэсгийн дундаж	100%	100%		
		Нийт дундаж	100%			

ТАЙЛАН ХЯНАСАН
 БАГАНУУР ҮЙЛДВӨРЛЭЛ
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН
 ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА